



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 22 өдөр

Дугаар Б/14

Дадал сум

Б.Оюунбаатарыг Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын даргаар түр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг, 50 дугаар зүйлийн 50.1.5 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 22-ны 02 дугаар тогтоол, 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Дадал тохижилт" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын даргаар ажиллах хүсэлт гаргасан Болдын Оюунбаатарыг 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс түр томилж, хавсран гүйцэтгэж байсан Д.Даваадоржийн ажлыг хүлээлцүүлсүгэй.

2.Ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

|         |               |                                      |
|---------|---------------|--------------------------------------|
| Дарга:  | Д.Агаармандал | (Санхүү албаны дарга)                |
| Гишүүд: | М.Ариунгэрэл  | (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)  |
|         | Б.Мөнхтуяа    | ("Дадал тохижилт" ОНӨААТҮГ-ын нярав) |

3.Б.Оюунбаатарын үндсэн цалинг ТҮ-9 шатлалаар 1,558,000 (Нэг сая таван зуун тавин найман мянга) төгрөгөөр тогтоож, орон нутгийн нэмэгдлийг 40 (дөч) хувиар тооцон цалинжуулахыг нягтлан бодогч (Д.Даваадорж)-д даалгасугай.

4.Б.Оюунбаатарт ажилдаа хурдан дадлагажиж, холбогдох хууль журмыг хэрэгжүүлэн ажиллахыг үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.МӨНХХУЯГ

010000278